

Орон бүжгийг праматарыг нар нэгдээгүй! АНХ ДЭГЭЭР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

7 дахь жилдээ 60 (3324) 1974 оны 8 дугаар сарын 12 ДАВАА

ТАРВАГА ЗУРАМ АГНАЛТ ЭХЭЛЛЭЭ

Тарвага бол үнэт баялаг бөгөөд арьс тос нь экспортын чухал хэсэг мөн. Ийм учраас тарвага агналын ажлыг жил бүрийн 8 дугаар сарын 10-наас орон даяар эхлэн явуулдаг уламжлалтай билээ. Манай аймаг эх онд тарваганы арьс 88 мянга, тос 18 тонн, зурамын арьс 15 мянгийг бэлтгэж үйлдвэр экспортын хэрэгцээнд нийлүүлдэг.

Энэ чухал зорилгыг хугацаанд нь ханган биелүүлэх зохион байгуулалтын арга хэмжээг орон нутгийн нам, улс, худалдаа бэлтгэл, агнуурын байгууллагад тус тусад нь үйлдвэр хэрэгтэй. Өнгөрсөн гууд цаг алдалгүй авч явуулах хэрэгтэй. Өнгөрсөн онд аймгийн хэмжээгээр тарваганы арьс бэлтгэх төлөвлөгөөг 102,6 хувь буюу 3,0 мянган ширхэгээр давуулан биелүүлсний дотор Сэргэлэн, Мөнгөнморьт, Баянцогт, Баянжаргалан, Баяндэлгэр, Алтанбулаг, Баян сумд тарвага, зурамын арьс, тарваганы тос бэлтгэлийн төлөвлөгөөг хугацаанд нь үлэмж давуулан биелүүлж үйлдвэр баазад 75-82 хувийг нь 1, 2 дугаар зэргийн чанартай тушаасан юм.

Гэтэл Баянцагаан, Дэлгэрхаан, Өндөрширээт, Баянзүрх сумд тарвага, зурамын арьс, тарваганы тос бэлтгэх төлөвлөгөөг 29,0-83,0 хувиар тасалж улсын төлөвлөгөөний сахилга батыг ноцтой зөрчжээ.

Энэ нь тарвага, зурам агналт, тарваганы тос бэлтгэлийн ажлыг муу зохион байгуулж төлөвлөгөөний биелэлтэнд тавих хяналт шалгалтыг сулруулан анхид ангийн нийгэмлэгийн гишүүд, идэвхтнүүдийн дотор тодорхой ажил зохиож ан агнуурын бэлтгэл ажлыг урьдчилан хангааргүйгээс болжээ. Иймд анхид ангийн нийгэмлэгийн гишүүдтэй агналтын гэрээг хийж анхид ан агнуурын талбарт хувийн бэлтгэл буу, сум, хавх, тосны сав, гэр орон, унаа хөсөг, хүнсний хэрэгслэлтэйгээр гаргаж төлний дотор социалист уралдааныг эрчимтэй өрнүүлж явцыг нь 10 хоног тутам дүгнэн ажиллавал зохино.

Сайн чанарын арьс бэлтгэхэд өвчигчид онцгой үүрэгтэйг анхаарч төлнийг өвчиллийн ажилд мэргэжлээр сургаж дадлагажуулах нь чухал байна.

Энэ онд тарвага нэг бүрээс 300 грамм тос авбал улсын төлөвлөгөөг биелүүлэх болно.

1973 онд тарваганы тос бэлтгэх ажлыг агналтын бригад дээр үйлдвэр, сумны гар машиннаар машиндан тарваганы махыг мах төлөвлөгөөг биелүүлсэн Баянхайлж тос бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлсэн сумын анхдын туршлагыг анхид ангийн нийгэмлэгийн гишүүд, идэвхтнүүдийн дотор тодорхой ажил зохиож ан агнуурын бэлтгэл ажлыг урьдчилан хангааргүйгээс болжээ. Иймд анхид ангийн нийгэмлэгийн гишүүдтэй агналтын гэрээг хийж анхид ан агнуурын талбарт хувийн бэлтгэл буу, сум, хавх, тосны сав, гэр орон, унаа хөсөг, хүнсний хэрэгслэлтэйгээр гаргаж төлний дотор социалист уралдааныг эрчимтэй өрнүүлж явцыг нь 10 хоног тутам дүгнэн ажиллавал зохино.

Сайн чанарын арьс бэлтгэхэд өвчигчид онцгой үүрэгтэйг анхаарч төлнийг өвчиллийн ажилд мэргэжлээр сургаж дадлагажуулах нь чухал байна.

Энэ онд тарвага нэг бүрээс 300 грамм тос авбал улсын төлөвлөгөөг биелүүлэх болно.

1973 онд тарваганы тос бэлтгэх ажлыг агналтын бригад дээр үйлдвэр, сумны гар машиннаар машиндан тарваганы махыг мах төлөвлөгөөг биелүүлсэн Баянхайлж тос бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлсэн сумын анхдын туршлагыг анхид ангийн нийгэмлэгийн гишүүд, идэвхтнүүдийн дотор тодорхой ажил зохиож ан агнуурын бэлтгэл ажлыг урьдчилан хангааргүйгээс болжээ. Иймд анхид ангийн нийгэмлэгийн гишүүдтэй агналтын гэрээг хийж анхид ан агнуурын талбарт хувийн бэлтгэл буу, сум, хавх, тосны сав, гэр орон, унаа хөсөг, хүнсний хэрэгслэлтэйгээр гаргаж төлний дотор социалист уралдааныг эрчимтэй өрнүүлж явцыг нь 10 хоног тутам дүгнэн ажиллавал зохино.

Сайн чанарын арьс бэлтгэхэд өвчигчид онцгой үүрэгтэйг анхаарч төлнийг өвчиллийн ажилд мэргэжлээр сургаж дадлагажуулах нь чухал байна.

Энэ онд тарвага нэг бүрээс 300 грамм тос авбал улсын төлөвлөгөөг биелүүлэх болно.

1973 онд тарваганы тос бэлтгэх ажлыг агналтын бригад дээр үйлдвэр, сумны гар машиннаар машиндан тарваганы махыг мах төлөвлөгөөг биелүүлсэн Баянхайлж тос бэлтгэлийн төлөвлөгөөг биелүүлсэн сумын анхдын туршлагыг анхид ангийн нийгэмлэгийн гишүүд, идэвхтнүүдийн дотор тодорхой ажил зохиож ан агнуурын бэлтгэл ажлыг урьдчилан хангааргүйгээс болжээ. Иймд анхид ангийн нийгэмлэгийн гишүүдтэй агналтын гэрээг хийж анхид ан агнуурын талбарт хувийн бэлтгэл буу, сум, хавх, тосны сав, гэр орон, унаа хөсөг, хүнсний хэрэгслэлтэйгээр гаргаж төлний дотор социалист уралдааныг эрчимтэй өрнүүлж явцыг нь 10 хоног тутам дүгнэн ажиллавал зохино.

4000 КГ ЦАГААН АЛТ ИЛҮҮ

Заамар сум-нэгдэл хонин сүргийн оторлолтыг сайн хийсний үрээр хонь бүрээс ашиглах ноосны гарцыг нэмэгдүүлж хяргалтын ажлыг шуурхай зохион байгуулан социалист уралдааныг өрнүүлснээр хонь, хургаа богино хугацаанд ноослож 85 тонн уртын ноос, 3 тонн ахрын ноос тушаан төлөвлөгөөг 4000 кг буюу 4,5 хувиар давуулан биелүүлэв.

Ш. БЯМБАА
Б. ЭНХТАЙВАН

Цаг үеийн сэдвээр

Баргын хоолойд буй хадланчдын майханд Намжил гуайн ярихыг сонсон суутал сэтгэлд эг сайхан дууны бадаг эрхийг тэл буугаад ирлээ.

Хулст нуурын өвөөн дээр

Хурдан халиун морьт минь

Хувирашгүй зангаар өсгөсөн

Аав ээж хоёр минь гэж дуулдаг нь ингэтлээ уяхан санагдах нь юуных билээ.

—Бээлийн чинээ хүүгээ нэг ажил амьдралын дөртэй болгочихвол ч боллоо доо гээд ярьж суугаа бууралхан санчигтай эрийн яриа сэтгэлийг тэгтэл хөдөлгөдөг байна шүү. Би цагаа харлаа.

Хадланчид ирэх арайхан болоогүй байв.

Намжилын Болд гэж ямархан ханхар чийрэг эр удаан бодоруссаасаа буугаад майхны гурвалжин амаар багтаж ядан ороод ирэх бол гэж сэтгэлдээ би төсөөлж суулаа. Ганцхан намар бүх л сумын төлөвлөгөөг хадланчид тэнцэх өвс хаддаг улсын аварга хүн эцгийнх нь өхөөрдөн хэлснээр «Бээлийн чинээ» хүү байхаар яавч бодогдсонгүй.

Хүний үр хэзээ боловч эцэг эхдээ нийлхэн балчиргаар санагддаг хойно доо. Улсын аварга болчихсон хүүгээ энэ эцэг ажлын дөртэй болгохсон гэж мэрийсээр л яваа байх нээ.

Намжил гуай бол Өндөрширээт сумандаа хадлангийн механикжсан бригадын анх байгуулж

Намрын уудам хөндий ургацаараа гайхуулахад Намжил механикчийн бригад амжилтаараа гайхуулж явсан удаатай. Харин одоо хүү нь энэ алдрыг нь залгамжилж явна.

Тэгэж явахдаа хүү Болдыг тракторын жолоонд гарыг атгуулж, хадлангийн талбайд замыг заагаар эдүгээ намрын шивээ дөрвөнтөө халиурахад гарч ирсэн нь энээ. Намжил механикчийн бригад энэ жил 1800 тонн хадлан авах төлөвлөгөөгөө 9 дүгээр сарын 1-ний наана биелүүлэхээр шамдаж

СЭТГЭЛИЙН ТЭМҮҮЛЭЛ

Намжил гуай миний хүү яаж ажиллахаараа 5 өдөрт 6-7 өдрийн ажил хийчихдэг юм болоо? Ноднин жил 1690 тонн өвс хаддаг улсын аварга болсон.

Энэ жил 850 тонн өвс хаддаг төлөвлөгөөгөө 100 тоноор давуулах үүрэг авсан, өдрийнхөө төлөвлөгөөг 130-аас дээш л биелүүлээд байна. Одоогийн амжилтаас нь харахад, санасандаа хүрэх нь дамжиггүй.

Чухам яаж ажиллаад бусдаас илүү амжилт гаргаж байгаа юм бол доо. Өөрөө лав нэгийг мэдэж байгаа гэж болно.

Хүүгээ амжилтын оргилд хүргэхийн төлөө эцгийн сэтгэл ингэж тэмүүлсээр...

Трактор дуугарч Намжил механикчийн хүү ирлээ. Миний төсөөлж бодсонтой огт адилгүй намхан чийрэг биетэй, гавшгай хөдөлгөөнтэй, сайхан алаг нүдээр энэ тэрийг нэвт шувт ажигласан сэргэлэн хүү байв. Алдар нэрийн сүр гэж байдаг болохоор тэгтлээ ханагар эр байхаар бодоо юу даа би.

Болд 19 настай, эвлэлийн гишүүн хүн юм.

Тэр жирийн тракторчийн амьдралаа нэр төртэй эхэлжээ.

—Амьдралаа гэдэг өөртөө байгаа хамаг л сайн сайхнаа хүний төлөө зориулахын утга юм даа.

Хүн баярлаж байвал нас нь нэмэгддэг гэж өвгөд ярьдагсан.

Өдрийн уралдааны дүн (Тогсгоод нь II нүүрт)

ЗХУ-д

ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн түрүүчийн сонгуулиас хойшхи дөрвөн жилд Москва хотын бараг хоёр сая хүн орон сууцныхаа нөхцөлийг сайжруулжээ.

Энэ жил Москвагийн 370 мянган хүн шинэ сууцанд орно.

Урьдын адил ой модтой зах нийлсэн районд орон сууц олныг барьж байгуулна. Нийслэлийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө ёсоор орон сууцны зэргээс эхлэн, эмнэлэг, төв, суурь газар байгуулчигдана.

Шинээр барьж байгаа бүх орон сууц хамгийн хилэг сайхан бөгөөд олон давхар барилга байх болно.



Москвагийн худалдааны тээврийн 16 дугаар авто баазын мастерууд МАЗ-504 машины суурь дээр АЦПТ-11 гэдэг хагас чиргүүлийг ашиглан сүү тээвэрлэгчийг шинээр бүтээжээ.

Шинээр бүтээсэн сүү тээвэрлэгч нь уртаараа 23 метр бөгөөд 22 тоннын даацтай, цагт 50 км хурдалж чадна.

ЗУРАГ ДЭЭР: Шинээр бүтээсэн сүү тээвэрлэгч—автопоезд



БҮДҮҮН УХААД

Бүрэн сум энэ онд 1800 тонн хадлан, зуун мянган зоодой бусад гар тэжээл бэлтгэх төлөвлөгөөтэй юм. Тус сумын нутаг гандуу ургац шингэн байгаа учир Өндөрширээт сумын нутаг «Бүдүүн ухаа» гэдэг газар тракторын нэг бригад гарган хадлангаа бэлтгэж байна. Сумын нам, захиргаа, нэгдлийн зөвлөл ургац муу байгаад дүгнэлт хийж 8 дугаар сарын 1-ний байдлаар 800 хүнд 150 тонн өвс, 110 мянган зоодой бэлтгэх даалгавар гардуулсны дээр айл өрхийн сум, бригадын хариуцлагатан нарт хариуцуулан, МАХН-ын гишүүд, орлогч гишүүдэд «онцгой даалгавар» өгч хадланг бүх нийтийн үйлс болгон өрнүүлжээ. Хадланчдын ажлыг өдөр бүр дүгнэж цуваагаар байр эзлүүлж байна. Саяхан эхний 10 хоногийн уралдаан дүгнэхэд хадагч П. Баасанжав

МТЗ-5 трактороор 53,1 тонн өвс хадаж 1 байр, хадагч Жигмиддорж, Хандиймаа нар II, III байр, пресслэгч Бадарч тав хоногт 2690 боодол өвс боож тэргүүн байр эзлэв.

Намын гишүүн Ч. Амгаа даргатай механикжсан бригадынхан 10 хоногт 617 га газар хадаж 201,2 тонн өвс бэлтгэжээ.

Мөн залуу хадланч Лхагваа, Чойжамц, Төртөгтох, Дагвадэмбэрэл, слесарь Ц. Осор, тогооч Батбаатар, Норов нарын тэргүүний залуучууд хадлангийн ажилд идэвхтэй сайн ажиллаж байна.

Зоодой бусад гар тэжээл бэлтгэх ажилд эмэгтэйчүүд шуурхайлан ажиллаж байгаагийн дотор Д. Цэдэвсүрэн, Х.Бүжинлхам нар тус бүр 1000 ширхэг, Гомбо, Чанцал нар 350-400 ширхэг зоодой бэлтгэлээ.

Н. ХАНДСҮРЭН

ХАДЛАНЧДЫГ ХОШУУЧИЛЖ ЯВНА

Алтанбулаг сумын залуучууд энэ онд сумынхаа хадаг өвсний 60 хувийг хадахаар социалист уралдаанд үүрэг амлалт авч залуучуудын нэрэмжит морин машины 2 бригад, хагас механикжсан салаа 1-ийг Тэмээн чулуут, Цагаан хөтөл, Үхэрчулуут зэрэг газар гаргаад ажиллаж байна.

Саяхан дүнгэсэн уралдаануудад МХЗЭ-ийн гишүүн Рэгзэн ахлагчтай Алтан-овоо бригадын хадланчид өдөр бүрийн нормоо 110-115 хувиар биелүүлж 2 удаа түрүүлээ.

Залуучуудын энэ бригадынхан МХЗЭ-ийн анхан шатны байгууллагын на-

рийн бичгийн дарга нарын улсын зөвлөлтөөн угтаж сумын аварга хадланчин Ч. Цэрэндоржийн туршлагаар ажиллан бригадынхаа хадлангийн 60 хувийг хадахаар үүрэг аваад хадлангийн эхний 14 хоногт морин машинаар 33 тонн өвс хадаж уралдааныг хошуучлан явна.

Мөн тракторч Б.Эрдэнэ, Ц. Пүрэвэ, С. Баатар нарын олон залуус өдөр бүрийн нормоо давуулан биелүүлж байна.

Ийнхүү тус сумын залуучууд өвс ногооны шим тэжээл буурахаас урьтаж мал сүрэгтээ арвин тэжээл бэлтгэх ажилд хадланчдыг үлгэрлэж байна. Л. ХЭНЧ-ЯАХВ

ҮНЭЭ ХЭЭЛТҮҮЛЭГТ ОНЦГОЙ АНХААРЪЯ

Үнээний хээлтүүлэгт муу анхаарснаас жил бүр олон зуун үнээ сувайрч хээлтүүлгийн ажил удааширнаас тугалалт оройтож сүү сааль алдах, төл нь хэнээрч, өвөл, хаврын улиралд олноор хоргодох, цаашид бэлтгэлийн насанд зохих жинд хүрэхгүй байх зэргээр эдийн засагт ихээхэн хохирол учирч байсан өмнөх жилүүдийн байдал сум, бригад, ферм бүр дүгнэлт хийж үнээ хээлтүүлгийн ажлыг эрчимжүүлж чанарыг сайжруулахад онцгой анхаарах нь чухал байна.

Наймдугаар сарын нэгний байдлаар аймгийн хэмжээгээр хээлтүүлэгт орох үнээний 57,2 хувь нь хээл авч өнгөрсөн оны

мөн үеийнхээс үнээний хээл авалт 46,1 хувиар илүү байгаа боловч Баянжаргалан, Эрдэнэ, Баян зэрэг сумдад үнээ хээлтүүлгийн ажил удаашралтай зохион байгуулалт муутай явагдаж байна.

Үхэр сүргийн үүлдэр, ашиг шимийг дээшлүүлэх чухал нөхцөл болсон зохиомол хээлтүүлгийн төлөвлөгөөг Лүн, Заамар, Баянзүрх, Эрдэнэ зэрэг сум таслаж болзошгүй байгааг анхаарч шуурхай арга хэмжээ авбал зохино. Мөн Баянжаргалан, Баянцагаан, Дэлгэрхаан, Өндөрширээт, Эрдэнэсат сумдад үнээнд гардан хээлтүүлэг хийгээгийн дээр ихэнх сумдад ердийн хээлтүүлгийн дэвшилтэт

аргыг хангалтгүй хэрэглэж байна.

Иймд эдгээр сумын зоо-техникч, малын эмч нар ажилдаа дүгнэлт хийж хээлтүүлгийн ажлыг шууд удирдан зохион байгуулж техникч малчдыг энэ ажилд дагалдуулан сургах хэрэгтэй. Үнээ, бухны тохироог бригад, сууриар нарийвчлан судалж бухныг нэмэгдэл тэжээлдээр тэжээж үнээнээс тусал нь малдуулж, өглөө оройн саалийн үед үнээний ороог шалган хээлтүүлэгт оруулах, шөнө уяж тэжээх зэргээр ердийн хээлтүүлгийн дэвшилтэт аргыг өргөн хэрэглэх шаардлагатай байна.

Бухны тэжээлийн төрлийг олшруулж, уургави-

таминээр баялаг хүчит тэжээл, өндөг, сүү хүрэлцэхүйц хэмжээгээр өгч байхын хамт үнээний бэлчээрийг нарийн хуваарьтай, ээлж дараатай ашиглаж нэмэгдэл тэжээл өгөх, сүүн тасаг, хээлтүүлгийн салбарыг нутаг сэлгэн нүүлгэх зэргээр хариулдаг маллагааны чанарыг эрс дээшлүүлэх хэрэгтэй.

Гардан хээлтүүлэгт ашиглаж байгаа бухны үрийн чанарыг сард 3-аас доошгүй удаа, зохиомол хээлтүүлэгт ашиглахаар авсан үрийг тухай бүр урьдчилан чанарын шалгалтыг заавал хийж байвал зохино. Гардан базохомол хээлтүүлгийн салбарыг хээлтүүлсэн үнээг 2-4 цагаар уяж давтан хээлтүүлэгд гаргаж байх нь зүйтэй.

Үнээний бухсалтыг идэвхжүүлэхийн тулд тэжээл арчилгааг сайжруулахаас гадна умайн амсарт нэг хувийн модон ханд түрхэх, өндөгчийн фолькулийн өсөлтийг түргэсгэх зорилгоор төрөл бүрийн био-идэвхжүүлэгчийг ашиглах, өндөгчинд нь илэлт хийх, бухсаж байгаа үнээний үтрээг 20-30 хувийн чихрийн уусмалаар угааж хээл авалтыг сайжруулах аргыг өргөн хэрэглэх нь чухал байна.

Үнээний суурь бүрт хээлтүүлгийн журнал, техникчийн хуанлийг хөтлүүлж, түүнд тавих хяналт шалгалтыг сайжруулбал зохино.

Зоо-техникч Д. ПҮРЭВ

ЗХУ—ЫН НИСЭХ ХҮЧИН

Уламжлал ёсоор энэ оны 8 дугаар сарын 18-нд улсаа их ЗХУ-ын нисэх хүчний их баяр болох гэж байна.

Зөвлөлтийн цэргийн нисэх хүчин их октябрийн өдрүүдэд үүсэн тогтсон бөгөөд иргэний дайны жилүүдэд 235 нисэгч төрийн дээд шагнал «Улаан тул»-ийн одонгоор шагнагджээ. Челюскинчүүдийг аварсан долоон нисэгчид ЗСБНХУ-ын баатар цол хүртжээ.

Дайны жилүүдэд Зөвлөлтийн нисэгчид 3 сая гаруй нислэг хийж Зөвлөлт, Германы фронт дээр дайсны 77 мянган онгоц сөнөөсний 55 мянга нь баатар нисэгчдийн мэргэн галд оногджээ.

Эх орны дайны үед баатарлаг гавьяа байгуулсан эрхлэх хөвгүүдэд Зөвлөлт эх орон өндрөөр үнэлж 200 мянга гаруй нисэгчид одон медалиар шагнагдсан юм. 2420 хүн ЗХУ-ын баатар цол хүртсний 65 нь эрхэм дээд цолыг 2 удаа, алдарт нис-

гэгч А.И. Покришкин, И. Н. Кождуб нар 3 дахь удаагаа тус тус хүртжээ. Нисэх хүчний 897 нэгдэл, анги ЗХУ-ын одон, 708 нэгдэл анги хүндэт нэр алдар, 288 нэгдэл анги гвардчууд гэдэг алдар нэр тус тус хүртжээ.

Дайны жилүүдэд Германд 78,9 мянган нисэх онгоц үйлдвэрлэсэн бол Зөвлөлтийн аж үйлдвэр 137,0 мянган нисэх онгоц үйлдвэрлэсэн бөгөөд дайны үед зөвлөлтийн онгоцны тоо 5 дахин өсчээ.

ЗХУ-ын цуврал үйлдвэрлэлээр шинэ маяг загварын нисэх онгоц 25, онгоцны мотор 23-ыг шинээр үйлдвэрлэжээ. Зөвлөлтийн цэрэг-агаарын нисэх хүчин сүүлийн жилүүдэд гариг хоорондын пуужин зөөгч, агаарын ямарч нөхцөлд нисдэг истерби-тель, бөмбөгдөгч истерби-тель, бөмбөгдөгч зэрэг

дуунаас хурдан шинэ маягийн онгоцтой болжээ.

Зөвлөлтийн агаарын зам нь дотооддоо 3500 гаруй хот, томоохон тосгон сууринг холбож агаарын замын нийт урт нь 616 мянган км-т хүрчээ. ЗХУ анх удаа 1922 онд хилийн цаана Германд агаарын зам нээжээ. Одоо ЗХУ-ын нисэх онгоц дэлхийн 60 гаруй орны буудалд бууж байна. 1974 онд аэрофлот 84 сая хүнд үйлчилж төрөл бүрийн ачаа тээвч, шуудан зэрэг 2 сая 200 мянга гаруй тонн ачааг онгоцоор тээвэрлэжээ.

Иргэний агаарын тээвэр улс ардын аж ахуйд чухал үүрэг гүйцэтгэж байна. 1973 онд ХАА-д 85,0 сая га талбайг бордож хорлогчидтой тэмцэх ажил хийжээ.

ЗХУ-ын иргэний агаарын тээврийн ажилчдын дотор ЗХУ-ын болон социалист хөдөлмөрийн баатар 200 гаруй ажиллаж байна.

СЭТГЭЛИЙН ТЭМҮҮЛЭЛ

Тогсгол. (Түрүүч нь I пүүрт)

гаргасан самбарын дэргэд хүмүүс цуглараад—за хэн нь торойж байна даа гэхэд аав бусдаас урьтаж—миний хүү түрүүлжээ гэнэ.

Нас ахиаараа сэтгэл хөдлөх нь амархан болчихдог юмуу даа...

Аваас дутуугүй манай бригадынхан бөөн байр болно. Амжилт бүтээл хүний сэтгэлд хүрч эзнээ баярдуулдаг. Би тэгж баярладаг. Нэг ангид сурч байсан нөхөр маань уулзаад: Өндөрширээт сумын харьяат энэ залуу 18 насандаа БНМАУ-ын аварга боллоо гээд л чамайг чинь улсын наадамд түрүүлсэн бөх шиг радиогоор сонсоход хичээн сайхан байгаа гэж билээ. Хүн хүнээ баярдуулах

шиг сайхай юм хаа байхав. Дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд Монголын бөх түрүүлэхэд зурагт үзэж суусан эрийн нүд нулимстай байхыг би үзсэн. Ганц хүний нүдэнд байрын нулимас хураагүй нь мэдээж. Тэр бөхийн амжилт хүмүүсийн зүрх сэтгэлд хүрч шүү дээ. Эх орноо баярдуулж амьдралаа гэгч юутай хувь билээ гэнэ.

Болд хүү ингэж эх орноо баярдуулахын төлөө хөдөлмөрт ухаан бяраа хөвчилдөг байна.

Бэр амтагдана гэгчээр хийх ажил сэтгэлд багтаад, эзэмшсэн техник маань зангийг нь авсан морь шиг гарт ороод ирэхэд амжилт гаргаж болдог доо гэж ярих дуртай. Техникийг жолоодохдоо биш мэдэхдээ байдаг.

За асаалаа, мотор ажиллаж байна. Хөдөллөө, төчнөөн цэгт өчнөөн араа харьцаж байна гэдгийг сэтгэлдээ харагдтал мэдэхгүйгээр техникээ ойлгохгүй шүү дээ.

Ойлгохгүй л юм бол үйлчилгээ тосолгооны ач тусыг дутуу үнэлэх болно. Үйлчилгээгүйгээр техникийн «насыг» уртасгаж амжилт гаргаж чадахгүй гэж Болд ярьж байна.

Болдод хамгийн үнэнч шадар нь техник гэдэг нь мэдээж. Тэрээр 1972 онд аймгийн аварга болохдоо ч, «Тэргүүний тариаланч» алтан медаль хүртэхдээ ч, улсын аварга хадланчин болохдоо ч техникийн хүчийг ухаантайгаа хослуулж амжилтанд хүрсэн юм. Өнөө ч гэсэн энэ л арга барилаараа амжилтын оргилдод эх орноо гэсэн сэтгэлийнхээ тэжүүлээр жигүүрлэж явна.

Ш. ЦЭРЭНДОО

Малын зүй бүсийн ХОРОГДОЛТОЙ ТЭМЦЬЕ

АДУУН СҮРЭГ ӨСГӨХ АСУУДАЛД

Лүн сумын «Энх-туул» нэгдлийн нийгмийн адуун сүргийн тоо жил дараалан буурч сүүлийн 3 жилд 100 эхээс 17-30 унага авч байсан нь, ул, аймгийн дунджаас доогуур байгаад дүгнэлт хийж адууны хариуллаа маллагааг сайжруулан гүү нэг бүрийг бүрэн хээл авахуулж хээлийг хамгаалан унага бүрийг мэнд бойжуулах зорилгоор зохион байгуулалтын нилээд арга хэмжээ авсан нь зохих үр дүнд хүрэв.

Тус нэгдэл 1974 оны 4 дүгээр сард нийгмийн бүх адуунд үзлэг явуулж хээлтэй гүүг ялган суурилж тогтмол хариуллаа, шөнийн манаатай болгон гүүг унагалмагц тусгай

бүртгэл хөтөлж, унагыг малчдын байнгын хяналтын дор бойжуулж байгаа нь унага сүргээс гээгдэж харангасах, чононд идүүлэх, элдэв өвчнөөр өвчилж үхэх явдлыг багасгав. Адуунд азарга азаргаар нь зүсмийн бүртгэл хийн азаргыг гүүний нь хамт ялгаж, сувай гүүг сувай адууны суурьт нь үлдээж бусад азаргатай адуунаас ялгагдсан хээлтэй гүүг өөр азарганд хураалгах зэргээр хээлтэй гүүний суурийг 20 азарга, 265 гүүтэйгээр зохион байгуулж суурийн ахлагчаар намын гишүүн Доржсүрэнг томилон ажиллуулжээ.

МАН-д хийсэн үзлэгийн дүнгээс үзэхэд энэ жи-

лийн унага бойжуулалт 1973 оныхтой харьцуулбал дээгүүр хувьтай байна.

Ингэж хавар эрт ялгаж суурилах нь хээлтэй гүүний арчилгаа маллагаа тэжээллэгт тавих хяналт нэг цэгт төвлөрч ядарч доройтсоныг нь тэжээлд оруулах, төрөлтийн хүндрэл болсон үед цаг алдалгүй тусламж үзүүлэх боломжтой юм.

Мөн сувай адуунаасаа ялгагдсан гүүг ийш тийш ширүүн туух, үргэж цооох явдал гардаггүй.

Бас гүү унагалсны дараах эхний ороондоо хээл авч байгаа эсэхийг бүртгэн цаашид хээлтүүлгийн ажлыг зөв явуулах боломж олгоно.

Бэлчээр ашиглалтыг сайжруулж эр сувай адууг алсын оторт явуулах боломж олгохоос гадна гүүний сааль ашиглах үед тохиолддог гүүг сувайж саалинд оруулах явдал үгүй болж азарга азаргаар нь саалинд оруулах бололцоотой болно.

Ингэснээр сүү саалийг ашиглахын зэрэгцээ гүүг бүрэн хээл авахуулж,

хээлтэй гүүг ялгах үед олонхи азаргыг гүүтэй нь ялгадаг учраас байдсан гүүнүүд сувай гүүний хамт өөр азарганд хураагдах учир төрөл ойтсон үржүүлэг явагдахгүй болдог. Харин зарим нэг сувай гүүтэйгээ үлдсэн азарганд байгаа байдсан гүүг өөр азарганд хураагдах ажлыг сувай адууны сууриудад хийж байна.

Ингэж гүүний хээлтүү-

лэг төлөлтийг зохион байгуулсан нь адууны өсөлтийг шийдвэрлэгч гол зүйл унагыг бүрэн бойжуулах, гүү бүрийг хээл авахуулах сайн талтай юм.

Энэ аргыг нэгдэл, САА, МАА-н үйлдвэрлэлд нэвт рүүлэх нь адуун сүргийн нөхөн өсөлтийг сайжруулахад зохих үр дүнгээ өгөх нь дамжиггүй.

зоо-техникч БАНЗРАГЧ

6935 ТОГРОГОӨӨР

Аймгийн Урчуудын салбарын хамт олон аймгийн Намын XVI бага хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд социалист уралдааныг өрнүүлэн ажиллаж энэ оны 7 дугаар сарын орлогын төлөвлөгөөг 204,9 хувиар биелүүлсний дотор Базарсүрэн ахлагчтай торгон хэвлэлийн тасаг, 5735 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх төлөвлөгөөтэйгээс 12670 төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж сарын төлөвлөгөөгөө 6935 төгрөгийн бүтээгдэхүүнээр давуулан биелүүлж бусад

тасгаасаа түрүүлээ.

Ажилчдын дунд зарласан уралдаанд торгон хэвлэлийн хэвлэгч Ч.Пансандулам, цутгуурчин Сэдэд, Дашцэрэн нар мөн сарын төлөвлөгөөг 160—292 хувиар биелүүлж эхний байруудыг эзэллээ.

Урчуудын салбар нийт ажилчдын дунд соггүй бүтээгдэхүүн үйлдвэрлэх хөдөлгөөн өрнүүлэн ажилласны үрээр үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний 90 хувийг нэгдүгээр зэрэгт гаргажээ.

Ш. ЦЭРЭНДОО

СУМДЫН АДХ-ЫН ЧУУЛГАНЫ ҮР НӨЛӨӨ

Тус аймгийн сумдын АДХ-ын ээлжит чуулган тогтмолжиж жилд 3—4 удаа дунджаар депутатуудын 80-аас доошгүй хувийн ирцтэйгээр хийдэг болно.

Чуулганаар төрийн байгууллагын удирдлагын арга барилыг сайжруулах, мал сүргийг өсгөх, тазар тариалан, ХАА-н үйлдвэрлэлийн үр ашиг, хөдөлмөрдийн боловсролыг дээшлүүлэх, соёлжилт, худалдаа, холбооны үйлчилгээ, социалист хууль ёс сахиу, иргэний үүргийн биелэлт, хот сууринг тохижуулах, с о ц и а л с т уралдааныг өрнүүлэх, төлөвлөгөөт зорилт биелүүлэх, хөдөлмөрдийн эрэлт хүсэлтийг хүлээн авч барагдуулах зэрэг өргөн хүрээтэй асуудлыг сонгон авч хэлэлцэж байна.

Нийт сум, хот, хороод, АДХ-ын чуулган хуралдуулах хугацааг сарын өмнө товлон зарлаж угтаж зохиох зохицот ажлын төлөвлөгөө гаргаж ажиллах, өмнөх чуулганы шийдвэрийн биелэлт, гарсан санал шүүмжлэлийн мөрөөр зохиосон ажил мөн депутатын асуулгын хариуг илтгэдэг журам улам чанаржив.

Мөн АДХ-ын ээлжит чуулган бүрт байнгын комиссын хавсралт илтгэл тайланг тогтмол тавьж байна.

Сумдын чуулганд аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга, орлогч гишүүдээс оролцож зөвлөмж удирдамж өгдөгөөс гадна төлөөлөгч оролцуулж, уул чуулганы материалыг аймаг хүлээн авч нэгтгэн дүгнээд цаашид анхаарах зүйлийн та-

лаар зааварчилгааг жилд 2—оос доошгүй гаргаж биелэлтийг шалгаснаар сумдын чуулганы үйл ажиллагаа, гаргасан шийдвэрийн үр нөлөө дээшлэв.

Энэ талаар шинэ барил нэвтрүүлж ажиллаж байгаа Борнуур, Баяндэлгэр, Баянжаргалан, Угтаалцайдам, Батсүмбэр зэрэг олон сумдыг нэрлэж болно.

Борнуур сум чуулганаа угтаж болзолт уралдаан зарлаад чуулганы үеэр дүгнэх, Баяндэлгэр сум чуулганаар сайшаагдсан байгууллага, хүмүүст талархлын хуудас, шүүмжлэгдсэн байгууллага хүмүүст шаардах хуудас өгдөг байна.

Чуулганаар хэлэлцэх асуудлыг зөв сонгон авахын тулд өмнөх жилүүдэд хэлэлцсэн асуудлын судалгаанаас үндэслэж 1970 оноос эхлэн Борнуур, Баяндэлгэр, Баянжаргалан, Лүн, Өндөрширээт, Баян-өнжүүл, Баянцогт, Эрдэнэсэлт, Угтаал, Жаргалант, Заамар, Алтанбулаг сумд чуулганд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг 3—5 жил, зарим нь хурлын сонгуулийн хугацаагаар төлөвлөн ажиллах болов.

Бүх сумд хэлэлцэх асуудлыг төлөвлөхдөө депутат, байнгын комисс, идэвхтэн, албан газар, хүмүүсийн саналыг зориуд судлан шаардлагатайг сонгон авдаг байна.

Бүх сумд чуулганаа угтаж депутатуудын уулзалт хийдэг болсны дээр чуулганы үеэр депутатуудад үйлчлэх ажлыг тогтмолжуулав.

АДХ-ын чуулганд олон нийтийг оролцуулж хэлэлцэж байгаа асуудлын

агуулга ач холбогдлыг гүнзгий ойлгуулж танилцуулах, зарим тэргүүний хүмүүсийн санал туршлагыг чуулганаас гарах шийдвэрт тусгах, хөдөлмөрдийн санал хүсэлтийг хүлээн авч сонсох, хэлэлцсэн асуудлыг өргөн сурталчлах талаар Баянжаргалан, Баяндэлгэр, Батсүмбэр сумд нилээд ахицтай ажиллаж байна.

Нийт сум чуулганы үеэр байгууллага хүмүүсийн ажлыг ханын самбаараар дүгнэдэг болно. Чуулганыхаа шийдвэрийг биелүүлэхээр Баянцогт, Баян, Баянжаргалан, Баянцагаан, Баянчандмань, Батсүмбэр, Баян-Өнжүүл, Батсүмбэр, Баяндэлгэр зэрэг сумд шуурхай арга хэмжээний төлөвлөгөө гарган ажилладаг нь үр дүнгээ өгч байна.

Лүн, Эрдэнэсэлт, Баянцагаан, Заамар, Угтаал, Баян-Өнжүүл сумд захиргааны гишүүдээр удирдуулсан групп шалгалт хийх, сурталчлан туслах ажил зохиодог болжээ. Гэтэл Дэлгэрхаан, Эрдэнэ, Сэргэлэн сумдын АДХ-ын чуулганы шийдвэрийн биелэлт, үр нөлөө нь төдий л дээшилж чадаагүй байгаад дүгнэлт хийж ажиллах нь зүйтэй.

Сумдын АДХ-ын чуулганы үр нөлөөг дээшлүүлэхэд АДХ-ын гүйцэтгэх захиргаа, депутат, байнгын комиссын хамтын ажиллагаа чармайлт санаачлага ихээхэн нөлөөлөх учир энэ талаар гарч байгаа шинэ арга барилыг байнга хөгжүүлэн, чуулганы үр нөлөөг улам дээшлүүлэв.

Г. НАМБУУ



ЗХУ-ын улс ардын аж ахуйн үзэсгэлэнд Зөвлөлтийн шинэ автобусны үзэсгэлэн нээгдэв. Уг автобус байгаль цаг сурын ямар нөхцөлд ажиллахад зохицож, тохилог энэ автобус дулаануулах хүчирхэг систем, дулааныг найдвартай тусгаарлагчаар төхөөрөмжлөгдсөн. Автобус нь агаар маш бага температурт хасах 80 градус ч ажиллаж чадна. Зураг дээр: ЛИАЗ-677А маркийн автобус

ТАСС-ын гэрэл зураг.

ДАСГАЛ СУРГУУЛИЛТ

Тус аймагт биеийн тамир спортыг нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлж, тамирчид, сурагчдын спортын үр чадвар, амжилтыг дээшлүүлэх талаар санаачлагатай ажиллаж өөрсдийн сонгож авсан мэргэжилдээ өсч дадлага туршилга арвинтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа багш, дасгалжуулагчид цөөнгүй байна.

Манай ахмад багш, биеийн тамирын тэргүүний ажилтан, Эрдэнэсэлт сумын 8 жилийн дунд сургуулийн биеийн тамирын багш Дамдин өөрийн ажиллаж байгаа сум, сургуульдаа биеийн тамир спортыг сайн сурталчилж биеийн тамирыг нийтийн хөдөлгөөн болгон өрнүүлж, экскурс тойрон аялал зохиох, сургуулиараа биеийн чуулга байгуулан

ажиллаж байна.

Баяндэлгэр сумын 8 жилийн дунд сургуулийн биеийн тамирын багш Тамара, Жаргалантын 10 жилийн дунд сургуулийн биеийн тамирын багш Эрдэнэшоо, Зуунмод хотын 10 жилийн дунд сургуулийн Чоймбол, Дондовоо Батсүмбэрийн Аюушрагчаа, Заамар сумын Цэрэнноров, Ургац нийгэмлэгийн дасгалжуулагч Гантөмөр нарын багш, дасгалжуулагчид өөрсдийн эрхэлсэн ажилдаа идэвхи зүтгэлтэй ажиллаж спортын сургалт дасгалжуулалтын ажлаа системдэс дараалалтай эхэлж хичээлдээ программын шаардлагыг хангаж чадахуйц сайн бэлтгэж, орон нутгийн бололцоог ашиглаж, спортын

Төгсөл нь IV нүүрт

Хөдөлмөрчдийн хууль ЗҮЙН МЭДЛЭГТ

БНМАУ-ын Ардын Их Хурлын найм дахь удаагийн сонгуулийн III чуулган саяхан хуралдаж «Хөдөлмөрчдийн хууль эрхийн хүмүүжлийг улам дээшлүүлэх» гэсэн асуудал хэлэлцэж, чухал шийдвэр гаргалаа. Их хурлын чуулганы шийдвэрийг амьдралд хэрэгжүүлэх явдал манай ХАА-н байгууллагын ажилчин албан хаагчид, мэргэжилтэн, нийт гишүүдийн чухал зорилт болж байна.

Нэгдлийн гишүүдийн хууль эрхийн хүмүүжлийг дээшлүүлэхэд ХАА-н нэгдлийн үлгэрчилсэн дүрмийн заалт бүрийг гүнзгий ойлгож түүнийг ухамсартайгаар биелүүлэх явдал чухал байр суурь эзлэнэ. Ялангуяа үлгэрчилсэн дүрмэнд заагдсан гишүүнийхээ эрх үүргийг

зөв ойлгож биелүүлэх явдал чухал.

ХАА-н нэгдлийн гишүүд нь нийгмийн аж ахуйд ажиллах, оруулсан хөдөлмөрийн тоо чанараар хөлсөө авах нэгдлийн удирдах болон хянан шалгах байгууллагад сонгох насанд хүрмэгц сонгогдох, ХАА-н нэгдлийг удирдах

мэнд заасан тэтгэвэр тэтгэмжүүдийг авах, амины туслах аж ахуйг дүрмэнд заасан хэмжээнд эрхэлж, амины малаа малахад нэгдлийн бэлчээр үст цэгийг үнэ төлбөргүй ашиглах, нэгдлийн зөвлөлийн ажиллагааны талаар гомдол гаргах, нэгдлийн хөгжлийн асуудлаар санал тавих эрхтэй юм.

Энэ эрхээ эдлэх нөхцөл бололцоогоор бүрэн хангаж байгаа юм. Энэ эрхийг эдлэхдээ мөн дүр-

тэй оролцох, нийгмийн үйлдвэрлэлд чадлынхаа хирээр оролцон, хөдөлмөрийн тогтоосон доод хэмжээг биелүүлж хөдөлмөрийн сахилга батыг чанд сахин даалгасан ажлыг үнэнч шударгаар хийх.

Хөдөө аж ахуйн нэгдлийн дүрэм, дотоод журмыг хатуу баримтлан биелүүлэх, нэгдлийн зөвлөл, түүний тэргүүлэгчдийн тогтоол, бригадын зөвлөлийн шийдвэр, нэгдэл бригадын дарга нар болон

хий боловсрол, улс төрийн мэдлэгийн хэмжээг байнга дээшлүүлж, зоомал эмнэлэг, агротехник, техник-эдийн засгийн анхны мэдэгдэхүүнийг эзэмших, тэргүүн туршлага судлаж үйлдвэрлэлд нэвтрүүлэх.

Үйлдвэрлэлийн болон ахуйн соёлч байдлыг дээшлүүлэх, нийгмийн хэв журмыг хатуу сахих үүрэгтэй юм.

ХАА-н нэгдлийн гишүүн бүр бүтээгдэхүүний гарцыг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх, зардлыг багасгахад өөрийн үйл ажиллагааг чиглүүлснээрээ нийгмийн үйлдвэрлэлийг үр ашгтайгаар хөтлөн явуулах ажиллагааг хангана.

Ингэхээр нэгдлийн гишүүн бүр дүрмээр олгогдсон эрх үүргээ ямагт санаж ажилласнаар хууль зүйг хэлбэрэлтгүй биелүүлж, эрхийнхээ мэдлэгийн санг арвижуулж чадах юм.

Ч.ЗУНДУЙ

ХАА-Н НЭГДЛИЙН ГИШҮҮНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

хэрэгт оролцох, нэгдлийн үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн санал нүүмжлэл гаргах эрхээр хангагдсан байдаг.

Түүнчлэн үйлдвэрлэлийн мэргэжил, соёл ахуйн үйлчилгээг дээшлүүлэхэд болон орон сууц барихад ХАА-н нэгдлээс тусламж авах энэ дүр-

мээр тодорхойлогдсон үүргийг гуйвсгалгүй хэрэгжүүлэх ёстой юм.

Өөрөөр хэлбэл эрх үүрэг хоёрыг салгалгүй хооронд нь нягт холбож чадсанаар эрх үүрэг хангагдах юм. Дүрмэнд зааснаар нэгдлийн гишүүд нь: —Өөрийн хамтын аж ахуйн үйл ажиллагаанд идэвх-

бусад албан хариуцлагатны өгсөн үүрэг даалгавар, мэргэжил тэдний зөвлөлдөө зааврыг ёсчлон биелүүлэх. Улс нийгмийн өмч хөрөнгийг нүдний цэгцгүй мэт хайрлан хамгаалж, үрж шамшигдуулах болон аж ахуйг бус явдал гаргахгүй байх.

Өөрийн мэргэжил, ерөн-

Нэгдлийн гишүүдийн хувийн хэрэг

ХАА-н нэгдлийн холбооны III их хурлаас нэгдлийн гишүүдийг хувийн хэрэгтэй болгохоор шийдвэрлэсний дагуу тус аймгийн олонхи нэгдэл гишүүддээ хувийн хэрэг мэдэн хөтөлжээ.

«Саруул-амьдрал», Сүхбаатарын зам» нэгдэл гишүүддээ хувийн хэргийг бүрэн нээж, жил бүр баяжуулан, эмх цэгцтэй, албан хэрэг ёсоор хадгалж байна.

Гэтэл «Авдархангай», «Монгол—Солонгосын найрамда» нэгдэл гишүүдийн хувийн хэргийг бүрэн нээгээгүй, нээсэн

цөөн хувийн хэрэгтээ баяжилт хийгээгүй байна.

Нэгдлийн гишүүдийн хувийн хэргийг «Авдархангай» нэгдэлд шалган үзэхэд хувийн хэргийн асуултуудыг буруу нөхсөн ба огт бичээгүй, хагас дутуу нөхөн бичсэн, баяжилт хийгээгүй, биеийн зураггүй, олон тооны гишүүд хувийн хэрэггүй зэрэг дутагдал байлаа.

Иймээс дээрх дутагдлыг бүрэн засч бригадын зөвлөл, хүн нэг бүрийн ажлын тодорхойлолтыг жил бүр хийж, бригадын хөдөлмөрчдийн хурлаар хэлэлцүүлж, хувийн хэр-

гийн баяжилтыг жилд нэг удаа хийж байх ёстой. «Авдархангай» нэгдэл бригадын зөвлөл олон хүнд сахилга батын арга хэмжээ зэмлэл хүлээлгэдэг боловч нэгийг нь ч хувийн хэрэгт нь тэмдэглээгүй, шилжсэн, нас барсан зэрэгт хөдөлгөөн хийгээгүй, хэзээ ямар өвчнөөр нас барсан тухай эмнэлгийн магадлагаа аваагүй байгааг анхаарвал зохино.

Ер нь гишүүдийн хувийн гийг хөтлөж баяжуулах ажлыг эрс сайжруулах нь чухал байна.

Х. АЮУШ

ДАСГАЛ СУРГУУЛИЛТ

Төгсгөл. (Түрүүч нь III нүүрт)

хэрэглэл материал санаачлан хийж байна.

Гэвч орон нутагт биеийн тамир спортын ажлын эрч далайц төдийлөн сайнгүй байгаа нь биеийн тамир спортын нийгэмлэг, түүний анхан шатны байгууллагуудын ажилтай холбогдох боловч биеийн тамирын багш мэргэжилтнүүдийн ажиллагаанаас ихээхэн шалтгаалж байна.

Нам, улсын хайр нэвээлээр сурь хүмүүжээд мэргэжил эзэмшиж, үндсэн мэргэжил дээрээ тодорхой хугацаанд ажилласан боловч өнгөрсөн хугацаанд юу хийж бүтээв гэдэг талаар тодорхой үнэлэлт дүгнэлтгүй явдаг багш, мэргэжилтнүүд мэрсэр байна.

Багш мэргэжилтнүүдээс ЗХУ болон бусад социалист орнууд болон өөрийн орны багш, дасгалжуулагчдын ажлын арга

барилыг судлаж нэвтрүүлэх ажил хангалтгүй байна. Биеийн тамирын багш мэргэжилтнүүд, орон нутагт биеийн тамир спортын сургалт дасгалжуулагчдын болон үүр зөвлөлийн ажилд мэргэжлийн удирдлага туслахаа үзүүлэх явдал төдий л сайнгүй байна. Нөгөө талаар орон нутагт ажиллаж байгаа биеийн тамирын анхан шатны байгууллагуудын дарга нар ч хөдөлмөрчдийн коммунист хүмүүжлийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг болсон биеийн тамир спортын

мүүжлийн олон талыг чадамгай зохицуулж тамирчдын байгуул, нийтийн заалучид, сонин, цахилгаан хийг өргөжүүлж идэвхтэй ажилладаггүй, энэ ажилд хэргийн эргэлтнүүд, сэлүүдийн хүчийг татан тусуулж тэдний бүтээлч дэмжлэгийг авахаар оновчтой ажлыг зо-

хиох явдал шаардлагын хэмжээнд хүрээгүй байна.

Орон даяар бүх ард түмний социалист уралдааны эрчимтэй өрнөж байгаа энэ үед биеийн тамир спортыг нийтийн хүртээл болгож, түүгээр хичээл лэх сургуулиулах ажлыг эрс сайжруулах талаар биеийн тамирын анхан шатны байгууллага, багш дасгалжуулагчид оновчтой аргаар ажиллаж тавьж ажиллахаа эхэлжээ.

Ж. ДАГВА

1-ны сонирхолд


Хүн бүрийн үсний тоо янз янз байдаг.

Тухайлбал бор царайтай хүний үс 150 мянган ширхэг байхад цагаан царайных 80—100 мянган ширхэг байдаг гэж.

Хүний үсний ширхэг 2—4 жилд 1 удаа солигдоно.

Нэг ширхэг үс 120 грамм ачаа дааж чадна.

ҮЗЭСГЭЛЭНГИЙН ТАНХИМД



Холбооны Бүгд Найрамдах Герман Социалист Бүгд Найрамдах ЗХУ-ын худалдаа, үйлдвэр, ажлаа хэрэгч хүрээнийхний сонгох хууль болон байна. Түүний үзмэрийг зууны дэргэд.

139 НАСТАЙ

ДАА ТЭТГЭВЭРТ ГАРАВ

Уулын Агаев, Угс, гон Межид, хонь хариулжээ. Үүнээс 40 жилийг нь хамтралынхаа хонь хариулжээ.

Гурван жилийн өмнө нас ийм өндөр болсон, мөн эмч нарын зөвлөмжийг харгалзан хамтралын ерөнхий захиргаа арай амар ажил—үхэр хариулах нь зүйтэй гэж зөвлөжээ.

Урт насалсан энэ хүний бие хэлэх ямарч өвчингүй, эрүүл саруул, хөнгөн шингэн, одоо хир нь мориор явсаар байна.

Ухаан саруул, сийрэг хэвээр ажээ. Межид Агаев хоёр удаа гэрлэжээ. Одоогийн авгай нь 83 настай. Энэ өвгөний үр хүүхэд, ач гуч, зээ нар бүгд нийлээд 151 хүн бий.

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ